



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн тооцсугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ

141223092

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
дүгээр сарын 12 ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

01
1/15

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянзүрх дүүрэг, Эрүүл оршихуй өрхийн эрүүл мэндийн төв	1/2023	2 жил	2023.01.12	2025.01.12
2.	Баянзүрх дүүрэг, Өнөр энх мэнд өрхийн эрүүл мэндийн төв	2/2023	3 жил	2023.01.22	2026.01.22
3.	Хан-Уул дүүрэг, Хаш чагнуур өрхийн эрүүл мэндийн төв	3/2023	2 жил	2023.01.12	2025.01.12
4.	Баянгол дүүрэг, Гурван санчир өрхийн эрүүл мэндийн төв	4/2023	3 жил	2023.01.22	2026.01.22
5.	Сонгинохайрхан дүүрэг, Баянбигэр өрхийн эрүүл мэндийн төв	5/2023	3 жил	2023.01.20	2026.01.20
6.	ЭМЖОЖ ХХК-ийн эмнэлэг	6/2023	4 жил	2023.01.31	2027.01.31
7.	Апекс менежмент ХХК-ийн Сонмедикал центр Улаанбаатар эмнэлэг	7/2023	1 жил	2023.01.12	2024.01.12
8.	Баян-Өлгий аймаг, Буянт сумын эрүүл мэндийн төв	8/2023	1 жил	2023.01.12	2024.01.12
9.	Баян-Өлгий аймаг, Баяннуур сумын эрүүл мэндийн төв	9/2023	1 жил	2023.01.12	2024.01.12
10.	Говь-Алтай аймаг, Алтай сумын эрүүл мэндийн төв	10/2023	1 жил	2023.01.12	2024.01.12
11.	Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв	11/2023	2 жил	2023.01.20	2025.01.20
12.	Сэлэнгэ аймаг, Сайхан сумын эрүүл мэндийн төв	12/2023	2 жил	2023.01.20	2025.01.20
13.	Сэлэнгэ аймаг, Хүдэр сумын эрүүл мэндийн төв	13/2023	2 жил	2023.01.20	2025.01.20
14.	Төв аймаг, Архуст сумын эрүүл мэндийн төв	14/2023	3 жил	2023.01.21	2026.01.21
15.	Төв аймаг, Заамар сумын эрүүл мэндийн төв	15/2023	3 жил	2023.01.20	2026.01.20
16.	Төв аймаг, Лүн сумын эрүүл мэндийн төв	16/2023	2 жил	2023.01.20	2025.01.20
17.	Увс аймаг, Сагил сумын эрүүл мэндийн төв	17/2023	2 жил	2023.01.20	2025.01.20